УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 7 ДУГААР ЗҮЙЛИЙН 7.1 ДЭХ ХЭСГИЙН ЗААЛТТАЙ ХОЛБООТОЙ ГАДААД ОРНУУДЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

П. Амаржаргал, Ч. Базар, Ц. Болормаа, Г. Гэрэл, Б. Хатантуул

УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн заалттай холбоотой судалгаа

2010 оны 12 сарын 30 нд нэмэлт өөрчлөлт орсон “Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд” нэгдсэн хуралдаанаас бусад нээлттэй хуралдаанд зөвхөн хэлэлцэж байгаа асуудлыг боловсруулахад оролцсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн, нам, эвслийн бүлгийн ажлын албаны ажилтнууд, Тамгын газрын ажилтнууд болон гишүүдийн зөвлөх, туслахууд оролцож болохоор хуульчилсан билээ. Энэхүү заалттай холбоотой олон улсын жишгийг харьцуулан судаллаа.

Судалгааг Австрали, АНУ, БНХАУ, Япон, ОХУ, Франц, Шинэ Зеланд, ХБНГУ,Турк зэрэг есөн улс орны парламентын хуралдааны дэгийг зохицуулсан эрх зүйн актуудын хүрээнд авч үзэж. Мөн Парламентын хэлбэр, байгуулалтын хорооны нээлттэй ба хаалттай болон хосолсон хуралдаантай улс орнуудын судалгааны жагсаалт гаргалаа. Эдгээр улс орнуудын Парламентын хуралдааны дэгийг зохицуулсан эрх зүйн актуудын холбогдох хэсэг:

1. **Япон Улсын Танхимын Дэгийн Тухай Дүрэм**
   - 140 дүгээр зүйл. Санал хураалт явагдаж байх хугацаанд бүх нэвтрэн орох танхимын хаалгыг хаана.
   - 160 дугаар зүйл. Хуралдааны тэмдэглэлийг гишүүн бүрт болон олон нийтэд түгээн мэдээллэнэ.

2. **Оросын Холбооны Улсын Төрийн Думын Регламент**
   - 39 дүгээр зүйл.Төрийн Думын хаалттайгаас бусад хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлийг хэвлэн нийтлэнэ.

3. **Францын Үндэсний Ассамблейн Хуралдааны Дэг**
   - 59 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг. Нээлттэй хурал бүрийг тодорхойлж, бүрэн тайлбарыг албан ёсны сэтгүүлд нийтлэнэ.

4. **ХБНГУ-ын Бундестагийн Дэгийн тухай хууль**
   - 69 дүгээр зүйл.Хороо нь хуулиар хаалттай хуралдах ёстой. Хороо нь хэлэлцэж буй асуудлын нэг хэсгийг болон бүхлээр нь хэлэлцэхэд олон нийтэд нээлттэй байх бөгөөд танхимын багтаамжаас шалтгаалан хэвлэл мэдээллийнхэн болон иргэдийг зөвхөн сонсогчоор хуралдаанд оролцуулах тохиолдолд хуралдааныг нээлттэй явуулж болно.

5. **Бүгд Найрамдах Хятад Ард Улсын бүх ардын төлөөлөгчдийн их хурлын байнгын хороодын хуралдааны дүрэм**
   - 8 дугаар зүйл.Бүгд найрамдах хятад ард улсын ардын хурлын байнгын хорооны хуралдаан голдуу нээлттэй явагддаг. Хуралдаан эхлэх үед дотоодын хэвлэл мэдээллийн албыг урьж болон зохион байгуулж хуралдаанд оруулна. Байнгын хорооны хуралдаанд ажиглагчийн суудал байх ба үйлдвэрчний эвлэл, эмэгтэйчүүдийн холбоо болон эв хамтын залуучуудын эвлэл зэрэг нийгмийн байгууллагын хариуцагчийг ажиглагчаар оролцуулна.

6. Шинэ Зеландын Төлөөлөгчдийн танхимын Дэгийн тухай хууль

- 235 дугаар зүйл.Сонсголоос бусад тохиолдолд хороо нь хаалттай хуралдах ба Төлөөлөгчдийн танхимд хурлын дүнг илтгэх хүртэл мэдээлэл нууц байна.
- 238 дугаар зүйл. Хуралдаан даргалагч олон нийтэд тухайн асуудлаар мэдэгдэл хийж болно.

7. Турк улсын Үндэсний Их Хуралд хэвлэл мэдээлэлийн төлөөлөгчдийн ажиллах журам

- 14 дугаар зүйл. Парламентын сурвалжлагч нь нэгдсэн хуралдаан, зөвшөөрсөн тохиолдолд хороо болон намын бүлгүүдийн хуралд өөрсдөд нь тусгайлан бэлдсэн хэсгээс үзэж болно.

8. Австралийн Хуралдааны Дэг

- Байнгын хороодын хуралдаан хаалттай хуралддаг эсэх:

  Австрали улсын хувьд байнгын хорооны хуралдаан нээлттэй явуулах боловч шаардлагатай тохиолдолд хаалттай явуулах журам бүхий улс юм. Австралийн Парламентын дээд, доод танхим болох Сенат болон Төлөөлөгчдийн танхимын Байнгын, Дэд, Тусгай, Хамтарсан, Сонгогдсон болон Үндсэн хороо /*Main committee*/, түүнчлэн Нэгдсэн Чуулганы хуралдаан хэрхэн явуулах дэгийг Танхимын "**Standing and Sessional Orders**" хэмээх баримт бичгийн дагуу явуулдаг байна. Тус мэдээлэлд Австралийн Парламентын доод танхим болох Төлөөлөгчдийн танхимын "**Standing and Sessional Orders**"-ыг сонгон холбогдох мэдээллийг түүвэрлэн үзлээ.

  Тус баримт бичгийг Австралийн 41-р Парламентын Төлөөлөгчдийн Танхим 2004 онд шинэчлэн баталсан бөгөөд өнөөдрийг хүртэл нийт 16 удаа нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд сүүлд 2010 оны 10-р сарын 20-ны өдөр орсон өөрчлөлт байна. Хэдийгээр Австралийн Үндсэн хуулиар Парламентын хэлэлцүүлгийг нээлттэй явуулахаар заасан боловч "**Standing and Sessional Orders**" буюу Хуралдааны дэгийн 8-р бүлгийн 78-р зүйлд заасан "**Хаалттай хэлэлцэх асуудлууд**"-д дараахь зүйлүүд орсон байна. Үүнд:

  78 дугаар зүйл: Дараахь асуудлууд болон тохиолдлуудад хаалттай хуралдах бөгөөд хуралдаанаар хэлэлцсэн асуудалтай холбогдуулан нэмэлт өөрчлөлт, санал зөвлөмж гаргана:

  (a) Гишүүний бүрэн эрхийн хугацааг сунгах тохиолдолд (*тус дэгийн 1-т*)

  (b) Тогтсон албан ёсны ажлын өдрийг зарлаагүй тохиолдолд (*тус дэгийн 46-ийн е- т)*

  (c) Гишүүн бусдад ямар нэгэн байдлаар нөлөө үзүүлэх тохиолдолд (*тус дэгийн 65-т*)

  (d) Гишүүн бусдад нөлөөлөх тохиолдолд (*тус дэгийн 75-т*)

  (e) Хуралдаан, хэлэлцүүлэг түр хугацаагаар хойшлогдсон тохиолдолд (*тус дэгийн 79-т*)

  (f) Гишүүн удаан хугацаагаар олон нийтэд байр сууриа илэрхийлээгүй тохиолдолд (*тус дэгийн 80-т*)

  (g) Тодорхой сэдвээр яаралтай хэлэлцүүлэх асуудал (*тус дэгийн 81-т*)

  (h) Тулгамдаж буй асуудлаарх хуулийн төсөл, яаралтай хэлэлцэх асуудлууд, түүнчлэн нэн яаралтай хэлэлцэх асуудлаарх тунхагын дагуу хаалттай хуралдана. (*тус дэгийн 82-83-т)*

  (i) Гишүүний бүрэн эрхийг түдгэдзүүлэх тохиолдолд – (*тус дэгийн 94-т)*

(j) Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлаар Үндсэн хороо санал оруулсан тохиолдолд (*дэгийн 153-т*)

(k)Үндсэн хорооноос хуулийн төсөлтэй холбогдуулан илтгэл-тайлан хэлэлцүүлэхээр санал гаргасан тохиолдолд (*дэгийн 153-т*)

(l)Танхимд хуулийн төслийн хэтийн байдлын /*further proceedings*/ талаар хэлэлцэх тохиолдолд (*дэгийн 197-т*)

(m)Үндсэн хороонд хэлэлцэгдэх хуулийн төслийн талаар Танхимд санал оруулж буй тохиолдолд (*дэгийн 198-т*) байнгын хорооны хуралдааныг хаалттай явуулна.

Дэгийн дээрх заалттай холбогдуулан тодруулбал ***Main Committee*** буюу ***Үндсэн хороо*** хуулийн хоёрдугаар хэлэлцүүлгийг явуулах бөгөөд хуулийн төслийг зүйл заалт бүрээр нь нарийвчлан хэлэлцэж, ажил хэрэгч санал шүүмж энэ хорооны хуралдаан дээр өрнөдөг байна. Өөрөөр хэлбэл, Үндсэн хороо буюу Main Committee-д хуулийн төслийн гол зарчмын хэлэлцүүлгийг явуулдаг байна.Үндсэн хороонд Төлөөлөгчдийн танхимын бүх гишүүд багтана. Түүнчлэн, Хамтын Нөхөрлөлийн орнуудын нэгэн адилаар Австралид төсвийн хуулийн төсөл, гишүүний халдашгүй дархан байдал, нууцтай холбоотой аливаа асуудлаар хаалттай хэлэлцдэг байна. Эдгээрийг холбогдох хуулиудаар зохицуулсан байна.

- Парламентаас хэвлэл мэдээлэлтэй харилцах:

  Парламентаас олон нийттэй харилцах асуудлын хувьд Парламентын дээд, доод Танхимын ажлын алба болох Тамгын газарт нээлттэй хуралдааныг Парламентын тусгай суваг болон вэбсайтаар шууд дамжуулах чиг үүрэг бүхий Радио нэвтрүүлгийн хэлтэс, Хэвлэл мэдээлэл, Харилцаа холбооны хэлтэс, Олон нийттэй харилцах хэлтэс үйл ажиллагаа явуулна.

- Радио нэвтрүүлгийн хэлтэс

  Радио нэвтрүүлгийн хэлтэс нь Сенат, Төлөөлөгчдийн танхим, бүх байнгын хороодын нээлттэй хуралдаан, хэлэлцүүлэг, санал шүүмж, асуулгын цагийг орон даяар шууд дамжуулах үүргийг хүлээдэг хэлтэс юм. Уг хэлтэс нь бусад газар, хэлтэс, албадын нэгэн адил Парламентын ордонд байрлах бөгөөд 2 танхим бүхий телевизийн студи, хуралдааныг шууд дамжуулах удирдлагын өрөөнүүдтэй мэргэжлийн инженер, техникийн ажилчидтайгаар үйл ажиллагаагаа явуулдаг байна. Уг шууд нэвтрүүлгүүд нь орон даяар телевизийн сувгаар, дэлхий даяар Парламентын вэбсайтаар цацагддаг байна.

- Олон нийттэй харилцах хэлтэс

  Олон нийттэй харилцах хэлтэс Парламентын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй ил тод байлгах үндсэн чиг үүргийн дагуу ажилдаг.
  Иргэдийг Парламентын хоёр танхимын нэгдсэн хуралдаан болон Question time асуулт хариултын цаг, Парламентын ордонтой танилцуулах ажиллагааг хариуцан зохион байгуулдаг.

- Хэвлэл мэдээлэл харилцаа холбооны хэлтэс

  Тус хэлтэсийн үйл ажиллагааны гол зарчим нь Парламентаас гарч буй аливаа шийдвэрийг нэг талыг барьсан, улс төржсөн байдал үүсгэлгүйгээр ард түмэнд бодитой мэдээлэл хүргэх үндсэн чиглэлтэй байна. Энэхүү зарчмыг хангахын тулд тус хэлтэст Парламентын сэтгүүлчид ажилладаг байна.

  Хэвлэл мэдээлэл харилцаа холбооны хэлтэс нь Парламентын үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй байлгах үндсэн чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

  Уг хэлтэс нь улирал тутам хэлэлцэгдэж буй, анхаарал татсан, нийгэм эдийн засгийн ач холбогдол бүхий хуулийг олон нийтэд таниулах зорилгоор сэдэвчилсан сэтгүүл гаргах

бөгөөд тухайн сэтгүүлээр тусгайлан телевизийн нэвтрүүлэг бэлдэж DVD форматад оруулан архивлан хадгалдаг байна.

Түүнчлэн Парламентын вэбсайтанд тухайн хуультай холбоотой гишүүдийн байр суурь, ярилцлага, бэлдсэн нэвтрүүлгийг цаг тухайд нь байршуулах үүрэг хүлээн ажиллаж байна.

Уг хэлтэс нь бие даасан сэтгүүл, нэвтрүүлэг бэлдэх ажлаа 10 жилийн өмнөөс эхлүүлсэн туршлагатай байсан юм.

9. АНУ-ын Төлөөлөгчдийн танхим

АНУ-ын Төлөөлөгчдийн танхимын Нэгдсэн болон Байнгын хорооны хурал олон нийт болон хэвлэл мэдээллийн байгууллагад нээлттэй хуралддаг Төлөөлөгчдийн танхим нь олон нийтэд нээлттэй байх гэсэн зарчмыг гол болгодог.

Үйл ажиллагаагаа “Хуулийг хэрхэн хийх вэ” гэсэн хуралдааны журмаар явуулдаг. Үүнд:

- Нэгдсэн болон Байнгын хорооны хурал олон нийт болон хэвлэл мэдээллийн хэрэгсэлд байнгын нээлттэй байна;
- Хаалттай байх тохиолдол байх бөгөөд хэрвээ хэлэлцэж буй асуудал нь улсын нууцад хамаарах бол байнгын хорооны дарга гишүүдийн санал хураалтаар хуралдааныг “нээлттэй” эсвэл “хаалттай” явуулахыг тухайн үед нь шийдвэрлэнэ;
- Конгрессийг сурвалжлах хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тусгай зөвшөөрөл өгдөг бөгөөд зөвшөөрөл бүхий сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан сурвалжлах үйл ажиллагаагаа чөлөөтэй явуулдаг;
- Түүнчлэн тусгай зөвшөөрөл аваагүй ХМХ-ийн сэтгүүлч, ажилтнууд тухайн үед зөвшөөрөл авч нэгдсэн болон байнгын хорооны хуралдааныг сурвалжлах эрхтэй;
- Конгресс нь дэргэдээ Нэгдсэн болон байнгын хорооны хуралдааныг бүхэлд нь бичиж авах телестудитэй байдаг;
- Конгрессийн телестудийн бичлэгийг тусгай кабелийн телевизээр олон нийтэд 24 цагийн турш цацдаг. Тухайлбал, нэг өдөр 5 байнгын хороо хуралдлаа гэхэд бүгдийг нь дэс дарааллаар нь ямар нэгэн эвлүүлэг монтаж хийлгүйгээр олон нийтэд нэвтрүүлж үзүүлдэг;
- 2010 онд Конгрессийн нэгдсэн болон байнгийн хорооны хуралдааныг нэвтрүүлэх кабелийн сувгаа 2-оор нэмэгдүүлсэн. Нийт 3 кабелийн телевиз 24 цагийн турш явж байна;
- Хэрвээ ХМХ-ийн сурвалжлагч хүсэлт гаргавал Конгрессийн телестудийн видео бичлэгийг авч, конгрессийн талаархи мэдээлэлдээ ашиглаж болно.

* * *

Хавсралт

“УИХ-ЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ” ХУУЛИЙН 7 ДУГААР ЗҮЙЛИЙН 7.1 ДЭХ ХЭСГИЙН ЗААЛТТАй ХОЛБООТОЙ ГАДААД ОРНУУДЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Улс орон • Парламентын хэлбэр	Эрх зүйн акт	Эх бичвэр, сурвалж	Байнгын хорооны хуралдааны мэдээллийг хэвлэл мэдээллээр түгээх журам	Тайлбар

1. Япон • Хоёр танхимтай	Танхимын Дэгийн тухай дүрэм	**Article 160.** The minutes shall be printed and distributed to each Member and be available to the general public. 1) http://www.sangiin.go.jp/eng/law/rothoc/index.htm	160 дугаар зүйл. Хуралдааны тэмдэглэлийг гишүүн бүрт болон олон нийтэд түгээн мэдээллэнэ.	Нээлттэй
2. ОХУ • Хоёр танхимтай	Думын регламент	Л.Өлзийсайхан Парламентын хуралдааны дэгийн онол, арга зүйн үндэс 2010, хуудас 168	39 дүгээр зүйл.Төрийн Думын хаалттайгаас бусад хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлийг хэвлэн нийтлэнэ.	Нээлттэй
3. Герман • Хоёр танхимтай	Дэгийн тухай хууль	Geschdftsordnung des Deutschen Bundestages 15	69 дүгээр зүйл.Хороо нь хуулиар хаалттай хуралдах ёстой.Хороо нь хэлэлцэж буй асуудлын нэг хэсгийг болон бүхлээр нь хэлэлцэхэд олон нийтэд нээлттэй байхаар шийдвэр гаргаж болно. Танхимын багтаамжаас шалтгаалан хэвлэл мэдээлэлийнхэн болон иргэдийг зөвхөн сонсогчоор хуралдаанд оролцуулах тохиолдолд хуралдааныг нээлттэй явуулж болно.	Хаалттай
4. Франц • Хоёр танхимтай	Хуралдааны дэг	Л.Өлзийсайхан Парламентын хуралдааны дэгийн онол, арга зүйн үндэс 2010, хуудас 337	59 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг. Нээлттэй хурал бүрийг тодорхойлж, бүрэн тайлбарыг албан ёсны сэтгүүлд нийтлэнэ.	Нээлттэй
5. Шинэ Зеланд • Нэг танхимтай	Төлөөлөгчдийн Танхимын Дэг	Article.235 The proceedings of a select committee or a subcommittee other than during the hearing of evidence are not open to the public and remain strictly confidential to the committee until it reports to the House. Article.238 The chairperson of a select committee or a subcommittee may, with the agreement of the committee, make a public statement to inform the public of the nature of the committee's consideration of a matter.	235 дугаар зүйл. Онсголоос бусад тохиолдод Хороо нь хаалттай хуралдах ба Төлөөлөгчдийн танхимд хурлын дүнг илтгэх хүртэл мэдээлэл нууц байна. 238 дугаар зүйл. Хуралдаан даргалагч олон нийтэд тухайн асуудлаар мэдэгдэл хийж болно.	Хаалттай
6. Турк • Нэг танхимтай	Үндэсний Их Хурлын хэвлэл мэдээлэлийн төлөөлөгчдийн ажиллах журам	MADDE 14 – Parlamento Muhabirleri; Genel Kurul toplantılarını, izinli olarak da komisyon ve siyasi parti grup toplantılarını kendilerine ayrılan yerlerde izleyebilirler.	14 дугаар зүйл. Парламентын сурвалжлагч нь нэгдсэн хуралдаан, зөвшөөрсөн тохиолдолд хороо болон намын бүлгүүдийн хуралд өөрсдөд нь тусгайлан бэлдсэн хэсгээс үзэж болно.	Хагас хаалттай

7. БНХАУ • Нэг танхимтай	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бүх Улсын Ардын төлөөлөгчдийн хурлын байнгын хороодын хуралдааны журам		8-р зүйл. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ардын хурлын Байнгын хорооны хуралдаан нээлттэй явагддаг. Хуралдаан эхлэх үед дотоодын хэвлэл мэдээллийн албыг урьж болон зохион байгуулж хуралдаанд оролцуулна. Байнгын хорооны хуралдаанд ажиглагчийн суудал байх ба үйлдвэрчний эвлэл, эмэгтэйчүүдийн холбоо болон эв хамтын залуучуудын эвлэл зэрэг нийгмийн байгууллагын хариуцагчийг ажиглагчаар оролцуулна.	Нээлттэй

8. Австрали • Хоёр танхимтай	Хуралдааны дэг	**78 Matters not open to debate** The following questions and motions are not open to debate, must be moved without comment and must be put immediately and resolved without amendment: (a) motion that a Member's time be extended (*standing order 1*); (b) motion that the business of the day be called on (*standing order 46(e)*); (c) motion that a Member be heard now (*standing order 65*); (d) motion that a Member be further heard (*standing order 75*); (e) motion that debate be adjourned (*standing order 79*); (f) motion that a Member be no longer heard (*standing order 80*); (g) motion that the question be now put (*standing order 81*); (h) question that the bill or motion be considered urgent, following a declaration of urgency (*standing orders 82 to 83*); (i) motion that a Member be suspended (*standing order 94*); (j) question that amendments made by the Main Committee be agreed to (*standing order 153*); (k) question that a bill reported from the Main Committee be agreed to (*standing order 153*); (l) motion that further proceedings on a bill be conducted in the House (*standing order 197*); (m) Question in the Main Committee that a bill be reported to the House (*standing order 198*). Should any of these questions be negative, no similar proposal shall be received if the Speaker is of the opinion that it is an abuse of the orders or forms of the House, or is moved for the purpose of obstructing business.	**Хуралдааны дэгийн** 78-р зүйл. Хаалттай хэлэлцэх асуудлууд: Дараахь асуудлууд болон тохиолдлуудад хаалттай хуралдах бөгөөд хуралдаанаар хэлэлцсэн асуудалтай холбогдуулан нэмэлт өөрчлөлт, санал зөвлөмж гаргана: -Гишүүний бүрэн эрхийн хугацааг сунгах тохиолдолд (*мус дэгийн 1-т*) -Тогтсон албан ёсны ажлын өдрийг зарлаагүй тохиолдолд (*мус дэгийн 46-ийн е-т)* -Гишүүн бусдад ямар нэгэн байдлаар нөлөө үзүүлэх тохиолдолд (*мус дэгийн 65-т*) -Гишүүн бусдад нөлөөлөх тохиолдолд (*мус дэгийн 75-т*) -Хуралдаан, хэлэлцүүлэг түр хугацаагаар хойшлогдсон тохиолдолд (*мус дэгийн 79-т*) -Гишүүн удаан хугацаагаар олон нийтэд байр сууриа илэрхийлээгүй тохиолдолд (*мус дэгийн 80-т*) -Тодорхой сэдвээр яаралтай хэлэлцүүлэх асуудал (*мус дэгийн 81-т*) -Тулгамдаж буй асуудлаарх хуулийн төсөл, яаралтай хэлэлцэх асуудлууд, түүнчлэн нэн яаралтай хэлэлцэх асуудлаарх тунхагын дагуу хаалттай хуралдана. (*мус дэгийн 82-83-т)* -Гишүүний бүрэн эрхийг түдгэдзүүлэх тохиолдолд (*мус дэгийн 94-т)* -Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлаар Үндсэн хороо санал оруулсан тохиолдолд (*дэгийн 153-т*) -Үндсэн хорооноос хуулийн төсөлтэй холбогдуулан илтгэл-тайлан хэлэлцүүлэхээр санал гаргасан тохиолдолд (*дэгийн 153-т*) -Танхимд хуулийн төслийн хэтийн байдлын /*further proceedings*/ талаар хэлэлцэх тохиолдолд (*дэгийн 197-т*) -Үндсэн хороонд хэлэлцэгдэх хуулийн төслийн талаар Танхимд санал оруулж буй тохиолдолд (*дэгийн 198-т*) байгын хорооны хуралдааныг хаалттай явуулна.	Нээлттэй бөгөөд хаалттай хуралдах тусгай тохиолдлууд байдаг. -Үндсэн хуулиараа Парламентын хуралдаан нээлттэй байхаар заасан ч "Хуралдааны дэг"-ийн 8-р бүлгийн 78-р зүйлд Парламентын хорооны гол хороо болох Үндсэн Хорооны хуралдааныг хаалттай явуулах гол үндэслэлийг заасан

9. АНУ • 2 танхимтай	АНУ-ын Төлөөлөгчдийн танхим “Хуулийг хэрхэн хийх вэ”	“HOW OUR LAWS ARE MADE” By John V. Sullivan, Parliamentarian, U.S. House of Representatives	-Нэгдсэн болон Байнгын хорооны хурал олон нийт болон хэвлэл мэдээллийн хэрэгсэлд байнгын нээлттэй байна; -Хаалттай байх тохиолдол байх бөгөөд хэрвээ хэлэлцэж буй асуудал нь улсын нууцад хамаарах бол байнгын хорооны дарга гишүүдийн санал хураалтаар хуралдааныг “нээлттэй” эсвэл “хаалттай” явуулахыг тухайн үед нь шийдвэрлэнэ; -Конгрессийг сурвалжлах хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тусгай зөвшөөрөл өгдөг бөгөөд зөвшөөрөл бүхий сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан сурвалжлах үйл ажиллагаагаа чөлөөтэй явуулдаг; -Тусгай зөвшөөрөл аваагүй ХМХ-ийн сэтгүүлч, ажилтнууд тухайн үед зөвшөөрөл авч нэгдсэн болон байнгын хорооны хуралдааныг сурвалжлах эрхтэй; -Конгресс нь дэргэдээ Нэгдсэн болон байнгын хорооны хуралдааныг бүхэлд нь бичиж авах телестудитэй байдаг; -Конгрессийн телестудийн бичлэгийг тусгай кабелийн телевизээр олон нийтэд 24 цагийн турш цацдаг. Тухайлбал, нэг өдөр 5 байнгын хороо хуралдлаа гэхэд бүгдийг нь дэс дараалаар нь ямар нэгэн эвлүүлэг монтаж хийлгүйгээр олон нийтэд нэвтрүүлж үзүүлдэг; -2010 онд Конгрессийн нэгдсэн болон байнгийн хорооны хуралдааныг нэвтрүүлэх кабелийн сувгаа 2-оор нэмэгдүүлсэн. Нийт 3 кабелийн телевиз 24 цагийн турш явж байна; -Хэрвээ ХМХ-ийн сурвалжлагч хүсэлт гаргавал Конгрессийн телестудийн видео бичлэгийг авч, конгрессийн талаархи мэдээлэлдээ ашиглаж болно.	Нээлттэй

* * *

Ашигласан материал

1) Marry Dean, Japanese Legal System, and second edition 2002
2) Л.Өлзийсайхан Парламентын хуралдааны дэгийн онол, арга зүйн үндэс 2010
3) “Standing and Session Order” Австралийн Төлөөлөгчдийн Танхим, 2010.10.20-ны нэмэлт өөрчлөлт орсон байдлаараа

4) http://www.sangiin.go.jp/eng/law/rothoc/index.htm /Япон улс /
5) http://www.text265.cn/qiyeguanli/gzzd/201005/110473.html /Хятад улс/
6) http://news.qq.com/a/20090424/001405_1.htm /Хятад улс/
7) http://www.aph.gov.au/house/pubs/standos/index.htm /Австрали/
8) http://www.parliament.nz/en-NZ/PB/SC/ /Шинэ Зеланд/
9) http://www.tbmm.gov.tr/genser/m31.html /Турк улс/
10) “HOW OUR LAWS ARE MADE” By John V. Sullivan, Parliamentarian, U.S. House of Representatives